СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН 1-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕР ЗАРЛАХ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 03 сарын 21-ний өдөр Дугаар№ 01 Сант сум

Ажлын хэсгийн хуралдаан 2025 оны 03 сарын 21-ний өдөр 09 цаг 20 минутад Сэлэнгэ аймгийн Сант сумын 1-р цэцэрлэгийн багш хөгжлийн өрөөнд 100%-ийн ирцтэй хуралдлаа.

Хуралдааны ирц: Сант сумын 1-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 03 сарын 14-ний өдөр А/09 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсгийн ахлагч Э.Эрдэнэзаяа, нарийн бичгийн дарга З.Оюунсүрэн, гишүүд Д.Нармандах, М.Оюунгэрэл, Л.Отгонцог нар оролцлоо.

Хэлэлцэх асуудал: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн худалдан авах, нийлүүлэх тендерийг нээх

Тендерийн нэр: Цэцэрлэгийн хүүхдийн хоол

Дугаар: СЭАСС1Ц/20250202001

Хэлэлцсэн нь: Хурал нээж ажлын хэсгийн ахлагч Э.Эрдэнэзаяа үг хэлэн хурал эхлүүлэв. За өнөөдөр худалдан авах ажиллагаатай холбоотой байгуулагдсан ажлын хэсгийн хуралдаан эхэлж байна. Энэ ажлын хэсэгт ахлагчаар Сант ЭМТ-ийн ахлах сувилагч Э.Эрдэнэзаяа миний бие, нарийн бичгийн даргаар Сант сумын төрийн сангийн мэргэжилтэн З.Оюунсүрэн, гишүүдэд 1-р цэцэрлэгийн багшийн туслах Д.Нармандах, 1-р цэцэрлэгийн нярав М.Оюунгэрэл, 1-р цэцэрлэгийн нягтлан бодогч Л.Отгонцог нар байгаа.

Л.Отгонцог: tender.gov.mn сайт дээр тендер шалгаруулалт явуулах зөвшөөрөл авсан, материалаа бүрдүүлээд тендер зарлахад бэлэн байгаа.

З.Оюунсүрэн: Тэгвэл одоо үнэлгээний хороогоо байгуулж цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаа скайнердаж оруулаад тендерийн бичиг баримтаа бэлдээрэй. Тендер нээж урилгаа илгээгээд ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэх хэрэгтэй. Тендерийн худалдан авах ажиллагааны төсөвт өртөг хэд билээ?

М.Оюунгэрэл: 46,896,000₮ хийгдэнэ. Оролцох боломжтой байгууллагуудад урилгаа цахимаар болон цаасаар, хүнсний бүтээгдэхийний үнийн саналтайгаа өгөх саналтай байна.

Д.Нармандах: Дэмжиж байна. Тэгэхгүй бол суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд хоцроод байдаг юм байна лээ.

Э.Эрдэнэзаяа: За ойлголоо. Тэгвэл тендерээ 3 сарын 24-ны 11 цагт нээвэл болж байна уу?

З.Оюунсүрэн: Болно. Дэмжиж байна.

М.Оюунгэрэл: Санал нэг байна.

Д.Нармандах: Би ч бас санал нэгдэж байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын хэсгийн гишүүдийн 100%-ийн саналаар тендерийн бичиг баримтыг цахимд байршуулж 2025 оны 03 сарын 31-ний өдөр 11 цаг хүртэл материал хүлээж авна, 3 сарын 24-ны 11 цаг 10 минутад нээхээр санал нэгдэв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН. ГИШҮҮН Л.ОТГОНЦОГ

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ Э.ЭРДЭНЭЗАЯА

ТАНИЛЦСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА З.ОЮУНСҮРЭН

ГИШҮҮД Д.НАРМАНДАХ

М.ОЮУНГЭРЭЛ